

2. Монголын АНУ судлалын төв Солонгосын Америк судлалын холбооны семинарт оролцсон нь

1997 оны аравдугаар сарын 17-19-нд Солонгосын Америк судлалын холбооны Олон улсын 32 дахь семинар Сеул хотоос зүүн хойш 200 гаруй километрийн зайд оршдог “Суанбо цэцэрлэг зочид буудал”-д болов. Уг семинар нь “Америк ба Ази: Соёлын зөрчил” гэсэн сэдвээр хийгдэж, дотроо: 1) Үндсэн гол санаа; 2) Азийн шашнуудын уламжлал ба Америкийн протестант шашны үзэл; 3) Ази-Америкийн утга зохиол ба соёл; 4) Дэлхий нийтийн хандлага ба Америкийн ардчилал; эдгээр 4 чиглэлээр илтгэлүүд тавигдлаа. Илтгэгч нар 20 минутаас хэтрүүлэхгүй ярих хатуу журамтай байв.

Семинарын ажиллагаа (илтгэлүүд, асуулт, хариулт, санал шүүмжлэл гаргах зэрэг цөм) зөвхөн англи хэл дээр явагдлаа.

Тус семинарт Солонгосын Америк судлалын холбооны удирдлагын хүмүүс, гишүүд, Солонгос дахь АНУ-ын мэдээллийн албаны удирдах зарим ажилтан, Солонгосын үндэсний их чуулган, гадаад орнуудыг судалдаг Солонгосын академи, Ханкук их сургууль, Солонгосын цэргийн академи, Солонгос судлалын академи, Солонгосын их сургууль, Сеул Чоннамын үндэсний их сургууль, Соган, Чонжү, Кюнбук, Данкоок, Донгүк, Хонгик, Дон-эүй, Хансүн, Мюнжи,

Кунжук, Чуннам, Ён нам, Кюнхи, Квандон, Кюнгхи, Чунбук, Сеулийн эмэгтэйчүүдийн, Сүншинны эмэгтэйчүүдийн, Эвхагийн эмэгтэйчүүдийн, Сүнкюнхван, Ёнсэн, Чун Ан, Кан нэүний их сургуулиуд, Солонгосын философи, шашны дээд сургуулийн эрдэмтэн багш нар, эдгээр сургуулиудын заримд нь ажиллаж буй америкийн сайн эрдэмтэн багш мэргэжилтнүүд, түүнчлэн зарим их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд оролцов.

Семинарт гадаадын орнуудаас АНУ, Япон, Монголын төлөөлөгчид уригдан оролцож, илтгэлүүд тавилаа. Семинарт Монголын АНУ судлалын Төвийн төлөөлөгчөөр миний бие оролцсоноос гадна Улаанбаатар дахь АНУ-ын мэдээллийн албыг төлөөлж Д.Баатардорж ажиглагчаар оролцлоо.

Семинарт нийтдээ 10 илтгэл тавигдаж, тэдгээртэй холбогдуулан албан ёсны шүүмжлэгч 10 хүн үг хэлэв. Үүнээс гадна асуултуудыг илтгэгч нарт тавьж хариу авч байлаа.

Зарим илтгэлээр албан ёсны бус шүүмжлэгч нар үг хэлсэн болно.